

**ТУВА ХЭЛЭН ДЭХ МОНГОЛ ЗЭЭЛЛЭГ  
ҮГСИЙН АВИА ЗҮЙН ОНЦЛОГ**

М.Ууганбаяр\*

Монгол хэлний хөгжлийн үе шатуудтай холбогдох авиа зүйн үндсэн шинж чанарыг тусгасны хувьд Тува хэлний үгийн санд байх монгол зээллэгүүдийн авиа зүйн дүр төрхийн үзэгдэл өөрөөр хэлбэл, монгол зээлэг үгийн авиа зүйн өөриймшилтэй холбоо бүхий асуудлуудыг эдгээр зээллэг үгийн түүхэн он цагийг илрүүлж зээлсэн уг сурвалжийг тогтоох зорилгоор судалдаг билээ /Татаринцев 1976:51 /.

Бид энэ удаа монгол зээллэгүүдийн орон зай, цаг хугацааны тэнхлэгийг тодорхойлох бололцоог олгож буй авиа зүйн үзэгдлийн /Татаринцев 1976: 52/ нэгэн жишээ болгон монгол хийгээд тува хэлний аль алиных нь нөлөөгөөр үүссэн тува хэлэн дэхь монгол зээллэг үгэнд хамаарах нэгэн төрөл урт эгшгийн талаар ярьж байна.

Тува хэлэн дэх зарим монгол зээллэг үгнээ голдуу тэргүүн үед тохиолдох оо, өө урт эгшиг нь монгол бичгийн хэлний агу, эгү/ау, эү/ бүтэц ба орчин цагийн монгол хэлний уу, үү гэсэн урт эгшигтэй тохирно. Жишээ нь:

Тув. доос “дуусах”, ЭМо. дагус-, ОМо. дуус-

Тув. оожум “уужим” ЭМо. агужим, ОМо. уужим

Тув. моода “сулрах” ЭМо. магуда-, ОМо. мууд

Тув. хойлу “хууль”, ЭМо. каули, ОМо. хууль

Тув. тоожу “тууж” ЭМо. тугужи, ОМо. тууж

Тув. тоолу “тууль” ЭМо. туули, Хал. тууль, ОМо. тууль

Тув. хоорза “гуурс, хоолой” ЭМо. гуурсу, ОМо. гуурс

Тув. хоолга “хуулга, хуулбар” ЭМо. кагулга, ОМо. хуулга

Тув. оорга “нуруу, язгуур, үндэс” ЭМо. уур монгул, ОМо. уур монгол /нируун монгол, уугуул монгол/

Тув. ооску “/өвчин/ хүндрэх, /гал хөс/ бадрах, /гал/ авалцах, /хувьсгал/эхлэх, /цуу хов/тарах түгэх” ЭМо. эгүскү, ОМо. үүсгэ-

Тув. хөөр “оршуулах, оршуулгын газар” ЭМо.кэгүр, ОМо.хүүр

Тув. чөөн “зүүн” ЭМо. жэгүн, ОМо. зүүн

Тув. төөгү “түүх” ЭМо.тэүкэ, ОМо. түүх, Хал. Дөр. түүк

Тув. сөөлү “сүүл” сон, ЭМо. сэгүлэ То. сөүл, Хал. сүл, ОМо. сүүл

/Татаринцев 1976: 66-68, ТРС 1968:321,322,483/

\* МУИС-ийн МХСС-ийн Хэлшинжлэлийн тэнхимийн багш, доктор (Ph.D)

Эл урт эгшгийн авианы өөриймшлийг судалсан Б. И. Татаринцев тува хэлний энэхүү оо урт эгшгийг монгол хэл аялгуунд байх түүний дундаа орчин цагийн монгол хэлэнд байх уу урт эгшгээс үүссэн гээд тоожу “тууж” тоол “тууль” тэргүүтэн үгнээ уруулшсан эгшгийг үзүүлэх хос тэмдэгтийг тувачууд урт о: гэж уншиж болохыг анхаарах хэрэгтэйг бичсэн байна /Татаринцев 1976:67/.

Б.И.Татаринцевийн үзэж буйгаар өө -ийн монгол хэлний ү: тэй тохирох жишээнүүдийн талаар ярих хүнд бэрх ба ойрдоос бусад бүх монгол хэл аялгууст дунд эгнээний уруулшсан хагас уйтан ү: байх бөгөөд энэ анхны үе дэхь урт эгшиг тува хэлний дэвсгэр дээр өө болж чадна. Иймээс тува хэлний төөгү монгол хэлний түүхээс тува хэлний сөөлү монгол хэлний сүүлээс үүссэн байж болно /Татаринцев 1976 : 68/

Түүнчлэн Б. И. Татаринцев, энэ мэт үгийн уг гарвалын талаархи асуудал нь монгол зээллэг үгс дэхь урт ө: нь өвөгхэвмаягууд дахь урт эгшгээс үүсч хөгжсөн гэх үзэл илүү үнэмшилтэй харагдах боловч одоогоор шийдэгдсэн хэмээн бодох хэрэггүй болохыг өгүүлж байна /Татаринцев 1976 : 68/.

Бид Татаринцевээс өөрөөр тува хэлэн дэх зээллэг үгсийн урт оо, өө эгшиг орчин цагийн монгол хэл болоод бусад монгол хэл аялгууны уу, үү эгшгээс үүсээгүй гэж үзэж байгаа билээ. Учир нь орчин цагийн монгол хэлний уу, үү эгшиг тува хэлэн дэхь монгол зээллэг үгнээ ч тохиолдоно. Жишээ нь,

Тув. хуурмак “худал, хуурмаг” ЭМо. кагурмаг, ОМо. хуурмаг  
Тув. уургай “ уурхай, сурвалж” ЭМо. агуркай, ОМо. уурхай

Б. И. Татаринцевийн “ Энэ мэт жишээнд урт эгшгүүд бие дааж үүссэн бол калчаа ба кеьжээ гэх зэрэг жишээнд байгаа шигээр /тува хэлэнд М. У./ оо -ийн оронд аа, өө-ийн оронд ээ илрэх байсан. Урт оо, өө нь өвөгхэвмаягууддаа урдаас бий болсон урт эгшгээс ирэлтэй хэмээн бүрэн тодорхойгоор хэлж болно. Тэгээд ч зээллэг үгс дэхь эгшгүүд уужим уруулшсан шинжтэй байгаа нь сонирхолтой ” гэх үзэл буруу юм /Татаринцев 1976: 67/

Учир нь тува хэлэн дэх энэхүү оо, өө, урт эгшиг нь эртний монгол хэлний агу, эгү бүтцийн монгол хэлэн дэх хөгжлийн онцлогийг тусгахгүй байгаа бөгөөд тува хэлэнд үүсч бий болсон эгшиг билээ. Тэгвэл, энд дурдах оо, өө урт эгшиг ямархуу шалтгаанаар эртний монгол хэлний агу, эгү бүтцээс үүсээгүй мөртлөө тува хэлэнд аа, ээ биш оо, өө гэх хэлбэртэй болсон байх вэ? Үүний шалтгааныг эдгээр урт эгшгийн монгол хэлнээс зээлэгдсэн үеийн нөхцөл байдалтай холбон үзвэл тодорхой болно.

Монгол хэлний хоёрдогч урт эгшиг VCV бүтцийн сүүлийн эгшиг нь утга ялгах өргөлттэй/secondary phoneme, суперсегментная фонема/ байсантай эсвэл уртаар дуудагддаг байсантай холбоотойгоор үүсч бий болсон байна /Nattori 1970:183, Рорр- 1959:4,6; 1962:271, Лувсанвандан 1967:21-22/. VCV бүтцээс үүсч бий болсон богино ба урт хоёр эгшгийн нийлэлгүйгээр хамт хэлэгдэж байсан жишээ монгол бичгийн хэл, эрт, дундад, орчин цагийн монгол хэл аялгуус түүнчлэн дөрвөлжин болоод тод үсгийн эх бичиг сурвалж дурсгалд олонтаа тохиолдоно. /Төмөртоогоо 1992:151-152/. Бие биетэйгээ нэгдэж нийлээгүй хэрнээ нэг дор хэлэгдэх хоёр

эгшгийн дундах гийгүүлэгч нь суларсан боловч амьсгалын түрэлтийн хэлбэрээр хадгалагдаж байгаа нь монгол хэлний урт эгшгийн үзэгдэлтэй холбоотой юм /Ууганбаяр 1994:58, Uuganbayar 2004:115/.

Бид монгол хэлний хоёрдогч урт эгшигтэй хамаа бүхий эл шинж онцлогийн жишээ болгож арвандолоодугаар зууны монгол хэлний ойрд аялгууны төлөөлөгч болох тод үсгийн дурсгалуудад тэр үед өөр хоорондоо нэгдээгүй байсан богино хийгээд урт эгшгийг

То. хаа:н “хаан”, ЭМо.каган, ОМо. хаан

То. йабуа:д “яваад”, ЭМо. ябугад, ОМо. яваад

То. долоа:н “долоо”, ЭМо. долуган, ОМо. долоо

То. хариа:д “хариад”, ЭМо. каригад, ОМо. хариад

То. дээ:рэ “дээр”, ЭМо. дэгэр-э, ОМо. дээр

То. оула “уул”, ЭМо. агула, ОМо. уул

То. өүлэн “үүл”, ЭМо. эгүлэн, ОМо. үүл гэх хэлбэрээр бичсэн болохыг/ Жамьян 1970:257-270/

түүнчлэн орчин цагийн баяд аман аялгуунд

Ба. тоаа “тоо”, ЭМо.тога, ОМо. тоо

Ба. хоаасин “хоосон”, ЭМо.хогусан, ОМо.хоосон

Ба. хоаалаа “хоолой”, ЭМо. хогулай, ОМо. хоолой

Ба. бөөр “бөөр”, ЭМо.бөгэрэ, ОМо. бөөр

Ба. бөиисин “бөөс”, ЭМо.бөгэсүн, ОМо.бөөс хэмээсэн байдлаар /Балдан, Цолоо 1972:25/

харин дархад аман аялгуунд

Да. арчиор “арчуур” ЭМо. арчигур, ОМо. алчуур, арчуур

Да. бороа:боро: “бороо”, ЭМо. боруг-а, ОМо.бороо

Да. тоа: “тоо” ЭМо. тог-а, ОМо. тоо

Да. бөө бө: “бөө”, ЭМо.бөге, ОМо. бөө /Шархүү 1984:137/хэлбэрээр хэлэгддэгийг зааж болно.

Бид дээрх жишээнээс үндэслэн VCV бүтцийн хөгжлийн явцын тодорхой нэгэн үе шатанд нэг нь нөгөөтэйгөө нэгдээгүй боловч цугтаа хэлэгдэх богино ба урт хоёр эгшигтэй монгол үгс нь тува хэлэнд зээлэгдэж орсны дараа түрэг хэлэн дэх урт эгшгийн үүсч хөгжих хууль зүйн дагуу эдгээр хоёр эгшгийн эхний эгшигт өргөлт ноогдож аажимдаа уртсан тува хэлний оо, өө урт эгшиг үүсч бий болсон байна гэж үзэж байна. Ташрамд дурдахад, Д. А. Павлов, тува хэлэн дэхь өө тэй жишээ нь тод үсэгт туссан дундад ойрд аялгууны онцлогийг харуулсан ойрд зээллэг үгс хэмээн үзсэн байдаг /Татаринцев 1976:68/.

Монгол хэлний дархад аман аялгуунд урт эгшиг бүрэлдэх онцлог нь тува хэлнийх лүгээ адилсаж байгаа нь сонин юм. Жишээ нь

Да. зоон “зуу” ЭМо. жагун, ОМо.зуу

Да. өөлэ “үүл” ЭМо. эгүлэ, ОМо. үүл /Ринчен 1964:110/

Да. билэ: “билүү” ЭМо. билэгү, ОМо.билүү

Да. битэ: “битүү” ЭМо. битэгү, ОМо. битүү

Да. харао:л “харуул” ЭМо. харагул ОМо. харуул  
Да. сарао:л “саруул” ЭМо. сарагул, ОМо.саруул  
Да. о:дам “уудам” ЭМо.агудам, ОМо. уудам /Шархүү 1984:134-135/

Уйгур- Урианхай хэлэн дэхь монгол зээллэг үгт ч оо, өө урт эгшиг байдаг.  
Жишээ нь,

УУ. горо: “хяруу” ЭМо.хирагу, ОМо. хяруу  
УУ. до:с “дуус ” ЭМо.дагус-, ОМо.дуусах  
УУ. хо:p “хуурах, шарах ” ЭМо.кагура-, ОМо хуур-/Болд 1977/76/:100/

Л.Болд Уйгур-Урианхай хэлэн дэх оо,өө урт эгшигтэй монгол зээллэг үг нь эрт цаг үед, өөрөөр хэлбэл монгол хэлэнд VCV бүтцээс хоёр эгшгийн хоорондох гийгүүлэгч сугараагүй байх үед зээлэгдсэн гэж үзэж байна. /Болд 1977/76/:100; 1978 :27; 1996: 12/

Тува хэлэн дэх оо, өө урт эгшигтэй монгол зээллэг үгсийг монгол бичгийн хэлний хэлбэрүүдтэй харьцуулах нь ч сонирхолтой болох ба монгол бичгийн хэлэнд нэг нь нөгөөтэйгөө нэгдээгүй, хоёр эгшгийн байдлаар бичигдэх зарим урт эгшиг тува хэлэнд оо, өө хэлбэртэй байна.

Жишээ нь,

Тув. хоойлу “хууль”, ЭМо. каули , ОМо. хууль  
Тув. хоорза “гуурс, хоолой” ЭМо. гуурсу, ОМо. гуурс  
Тув. оорга “нуруу, язгуур, үндэс” ЭМо. уур монггул, ОМо. уур монгол /нируун монгол, уугуул монгол/  
Тув. тоолу “тууль” ЭМо. туули , Хал. тууль, ОМо. тууль  
Тув. төөгү “түүх ” ЭМо.түүкэ, ОМо. түүх, Хал. Дөр. түүк /Татаринцев 1976: 52 ТРС 1968:321,322,483/

Эцэст нь хэлэхэд дээр дурьдсан тува хэлэн дэх оо, өө урт эгшигтэй монгол зээллэг үгс нь Л.Болдын үзэж байгаа шигээр эртний монгол хэлний VCV бүтцийн хоёр эгшгийн хоорондох гийгүүлэгч сугарах үзэгдэл өмнөх үед биш байлаа гэхэд тод бичгийн үеийн ойрад монгол аялгуу дархад аман аялгуу эсвэл дундад зууны монгол хэлний үед тува хэлэнд орсон байж болох билээ.

Тува хэлэн дэх монгол зээллэг үгс авиазүйн өөриймшлийн үзэгдлийг монгол хэлний авиа зүйн талаас гүнзгийрүүлэн судлах нь тува монгол хэлний түүхэн хэлхээ харилцаатай холбоо бүхий чухал асуудлуудыг тодруулахад хувь нэмэр болох нь гарцаагүй.

Товчилсон үг :

Ба. баяд аялгуу  
Да. дархад аялгуу  
Дөр. Дөрвөд аялгуу  
ОМо. Орчин цагийн монгол хэл  
То. тод бичиг  
Тув. Тува хэл

УУ. Уйгур урианхай хэл  
Хал. Халимаг хэл  
ЭМо. Эртний монгол хэл буюу монгол бичгийн хэл

### Summary

In this brief article author discusses about Mongolian long vowels oo ,өө that occur in Mongolian loan words in Touvinian. According to the author, loan words with these long vowels have been entered into Touvinian from clear script Oyrat Mongolian and Darkhat dialect and middle Mongolian.

### Ном зүй

- Балдан, Л., Ж.Цолоо, (1974) “Баяд аман аялгуу, аман зохиол судалсан зарим дүн ” *Шинжлэх ухааны академийн мэдээ* № 3 Улаанбаатар.
- Болд, Л., /1977/76//. “Монгол хэлнээс уйгур урианхай хэлэнд орсон үгсийн эгшиг авианы онцлог ”. *Хэл зохиол судлал XII/8/*. Улаанбаатар.
- Болд,Л., (1978) *Особенности уйгур-урянской языка*. Автореферат кандидатской диссертации. Улан-Батор.
- Болд, Л., (1996) *Исторические связи монгольского языка с саянскими тюркскими языками*. Автореферат докторской диссертации. Улан-Удэ.
- Жамъян, Г., (1970) “Тод үсгийн зөв бичгийн дүрэмд урт эгшгийг хэрхэн тэмдэглэсэн тухай асуудалд” *Монгол судлал VII*. Улаанбаатар.
- Лувсанвандан, Ш., (1967) “Орчин цагийн монгол хэлний урт эгшгийн гарлын тухай асуудалд” *Хэл зохиол IV*. Улаанбаатар.
- Ринчен, Б., (1964) *Монгол бичгийн хэлний зүй тэргүүн дэвтэр*. Улаанбаатар.
- Татаринцев, Б. И., (1976) *Монгольское языковое влияние на тувинскую лексику*. Тувинское книжное издательство. Кызыл.
- ТРС (1968) *Тувинско-русский словарь*, около 22000 слов. под редакцией Э. Р. Тенишева. Советская энциклопедия. Москва.
- Төмөртоогоо, Д., (1992) *Монгол хэлний түүхэн хэл зүйн үндэс. Монгол хэлний түүхэн авиан зүй. нэгдүгээр дэвтэр*. Улаанбаатар.
- Ууганбаяр М, (1994) “Монгол дөрвөлжин үсгийн шанаган а –ийн тухай асуудалд” Академич Ш. Лувсанванданы нэрэмжит их дээд сургуулийн оюутны эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл. Улаанбаатар.
- Шархүү, Ц., (1984) Дархадын аман аялгууны урт эгшгийн үүслийн тухай ” *МУИС эрдэм шинжилгээний бичиг* №3. Улаанбаатар.
- Hattori, Sh., (1970) ‘The length of Vowels in Proto Mongolian’. *Mongolian Studies*. Amsterdam.
- Poppe, N., (1959) ‘On the Velar Stops in Intervocalic Position in Mongolian’ *Ural-Altische Jahrbucher* 31.
- Poppe, N., (1962) ‘The Primary Long Vowels in Mongolian’ *Journal de la Societe Finno-Ougrienne*. 63:2.
- Uuganbayar M., (2004) “Tuvacadaki Mogolca kelime odunclemelerinin ses benimseme olayi uzerine bir ornek” *Cagdas Turkluk Arastirmalari Sempozyumu 2002 Bildiriler 8-10 Mayıs*, Ankara.